# БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Орхон сумын цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/125/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2026 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас: 70342716 Цахим хаяг: battsogtd@audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит” ХХК-ийн захирал: С.Оргил<br>Утас: 99197346 Цахим хаяг: info@shinjlenmagadlakhui-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт....................................................................3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .........................................5-9
3. Аудитын тайлан ..............................................................................................9-12
4. Аудитын илрүүлэлт ...................................................................................... 12-13
5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл...................................................**14**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 200.

танай _______________ны № _______________т

ОРХОН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.АРИУНЗАЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орхон сумын хүүхдийн цэцэрлэг нь 2025 онд 118 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж үүнээс 68 хүүхэд үндсэн цэцэрлэгт, 50 хүүхэд нь хувилбарт хөтөлбөрт хамрагдаж 100 хувь гүйцэтгэлээр санхүүжсэн.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Орхон сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Булган аймгийн боловсролын газрын даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлгээний төлөвлөгөө нь 1 хөтөлбөр, 65 арга хэмжээний хүрээнд 93.21 хувиар үнэлэгдсэн байна.

6326050220

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **I** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **113,127,082.01** | **99,439,633.71** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 83,734,042.01 | 39,140,703.71 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 83,734,042.01 | 39,140,703.71 |
| 3121 | Төгрөг | 83,734,042.01 | 39,140,703.71 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 83,734,042.01 | 39,140,703.71 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **29,393,040.00** | **60,298,930.00** |
| 351 | Түүхий эд материал | 30,400.00 | - |
| 35130 | Эм боох материал | 30,400.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 29,362,640.00 | 60,298,930.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 419,500.00 | 976,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 537,000.00 | 638,700.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 467,000.00 | 764,200.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,454,470.00 | 2,015,660.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 23,484,670.00 | 55,903,770.00 |
| **II** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **304,851,348.14** | **300,970,602.37** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **304,851,348.14** | **300,970,602.37** |
| 392 | Биет хөрөнгө | 288,900,347.83 | 284,785,852.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 306,959,700.00 | 322,934,700.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (73,756,673.28) | (86,182,577.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,715,976.00 | 33,038,490.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (19,826,462.49) | (19,398,472.02) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,610,196.70 | 31,411,696.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,661,010.42) | (11,672,294.70) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 29,063,034.00 | 29,063,034.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (13,761,166.68) | (17,014,978.80) |
| 39217 | Ном | 2,556,754.00 | 2,606,254.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 15,951,000.31 | 16,184,750.35 |
| 39301 | Програм хангамж | 2,350,000.00 | 2,800,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,044,999.69) | (1,261,249.65) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,646,000.00 | 14,646,000.00 |
| **III** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **417,978,430.15** | **400,410,236.08** |
| **IV** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **128,320.00** | **192,000.00** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 128,320.00 | 192,000.00 |
| 413 | Өглөг | 128,320.00 | 192,000.00 |
| 4136 | Бусад өглөг | 128,320.00 | 192,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 103,500.00 | 192,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 24,820.00 | - |
| **V** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **417,850,110.15** | **400,218,235.48** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 417,850,110.15 | 400,218,235.48 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 80,980,838.60 | 80,980,838.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 80,980,838.60 | 80,980,838.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 329,992,304.15 | 312,360,430.08 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 329,992,304.15 | 329,992,304.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (17,631,874.07) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,876,967.40 | 6,876,967.40 |
| **VI** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **417,978,430.15** | **400,410,235.48** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **417,147,790.00** | **448,056,700.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,770,690.00 | 30,274,100.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 12,770,690.00 | 30,274,100.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй авсан орлого- үндсэн хөрөнгө | 8,518,390.00 | |
| 120018 | Үнэ төлбөргүй авсан орлого- бараа материал | 4,252,300.00 | 30,274,100.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 404,377,100.00 | 417,782,600.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **357,481,300.00** | **364,211,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 357,481,300.00 | 364,211,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **46,895,800.00** | **53,571,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 46,895,800.00 | 53,571,400.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **413,999,762.93** | **481,663,574.07** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 413,999,762.93 | 481,663,574.07 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 413,590,290.25 | 475,819,577.76 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 265,756,456.58 | 324,980,489.18 |
| 210101 | Үндсэн цалин | 187,243,689.21 | 209,415,569.82 |
| 210102 | Нэмэгдэл | 74,344,967.37 | 95,229,377.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 9,490,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,167,800.00 | 10,845,541.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,314,000.54** | **40,235,147.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,735,203.67 | 27,461,671.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,367,329.17 | 3,155,952.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,597,356.54 | 1,577,976.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,296,292.64 | 1,577,976.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,317,818.52 | 6,461,569.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,314,627.32** | **47,559,833.69** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,453,075.15 | 4,088,494.56 |
| 210302 | Түлш, халаалт | 41,861,552.17 | 43,471,339.13 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **322,450.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 322,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **26,548,261.00** | **28,943,400.00** |
| 210502 | Хоол, хүнс | 26,548,261.00 | 28,943,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,094,700.00** | **-** |
| 210604 | Урсгал засвар | 1,094,700.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **385,000.00** | **160,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 385,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **41,177,244.81** | **33,618,257.77** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,576,645.16 | 10,433,012.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,189,350.00 | 500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,411,249.65 | 22,685,245.77 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 409,472.68 | 5,843,996.31 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 2,949,780.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,949,780.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 409,472.68 | 2,894,216.31 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 409,472.68 | 2,894,216.31 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,148,027.07** | **(33,606,874.07)** |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 811,008.17 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 811,008.17 | - |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (811,008.17) | - |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,337,018.90** | **(33,606,874.07)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **404,377,100.00** | **417,782,600.00** |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 404,377,100.00 | 417,782,600.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **357,481,300.00** | **364,211,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 357,481,300.00 | 364,211,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **46,895,800.00** | **53,571,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 46,895,800.00 | 53,571,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **384,870,200.94** | **461,435,938.30** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 384,870,200.94 | 461,435,938.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 384,460,728.26 | 455,567,121.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **269,330,190.40** | **325,571,286.30** |
| 210101 | Үндсэн цалин | 190,682,948.32 | 209,415,569.82 |
| 210102 | Нэмэгдэл | 74,479,442.08 | 95,820,174.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 9,490,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,167,800.00 | 10,845,541.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,314,000.54** | **38,925,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,501,035.54 | 26,471,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,601,497.30 | 3,114,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,452,008.53 | 1,557,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,441,640.65 | 1,557,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,317,818.52 | 6,223,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,013,876.52** | **47,559,833.69** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,152,324.35 | 4,088,494.56 |
| 210302 | Түлш, халаалт | 41,861,552.17 | 43,471,339.13 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,266,620.00** | **26,504,590.00** |
| 210502 | Хоол, хүнс | 25,266,620.00 | 26,504,590.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,472,450.80** | **3,117,350.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,472,450.80 | 3,117,350.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **385,000.00** | **610,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 385,000.00 | 610,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,678,590.00** | **13,278,662.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,234,020.00 | 11,008,342.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,444,570.00 | 2,270,320.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **409,472.68** | **5,868,816.31** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 2,974,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,974,600.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **409,472.68** | **2,894,216.31** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 409,472.68 | 2,894,216.31 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **19,506,899.06** | **(43,653,338.30)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,341,300.00** | **940,000.00** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,341,300.00 | 940,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,341,300.00 | 940,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 2,341,300.00 | 940,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,341,300.00)** | **(940,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **17,165,599.06** | **(44,593,338.30)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **83,734,042.01** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **83,734,042.01** | **39,140,703.71** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **80,980,838.60** | **6,876,967.40** | **329,992,304.15** | **417,850,110.15** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 80,980,838.60 | 6,876,967.40 | 329,992,304.15 | 417,850,110.15 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (62,328,893.14) | (62,328,893.14) |
| | | | | | |
| **D01** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **80,980,838.60** | **6,876,967.40** | **329,992,304.15** | **417,850,110.15** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 80,980,838.60 | 6,876,967.40 | 329,992,304.15 | 417,850,110.15 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 15,975,000.00 | - | - | 15,975,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (33,606,874.07) | (33,606,874.07) |
| **D09** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,955,838.60** | **6,876,967.40** | **296,385,430.08** | **400,218,236.08** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүнгээр | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **485,496,470.00** | **462,375,938.30** | **23,120,531.70** | 95.24 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **485,496,470.00** | **461,435,938.30** | **24,060,531.70** | 95.04 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 485,496,470.00 | 455,567,121.99 | 29,929,348.01 | 93.84 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **338,222,400.00** | **325,571,286.30** | **12,651,113.70** | 96.26 |
| 210101 | Үндсэн цалин | 211,448,600.00 | 209,415,569.82 | 2,033,030.18 | 99.04 |
| 210102 | Нэмэгдэл | 117,734,700.00 | 95,820,174.60 | 21,914,525.40 | 81.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 9,490,000.00 | | |
| 210104 | Урамшуулал | 9,039,100.00 | 10,845,541.88 | (1,806,441.88) | 119.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **41,947,600.00** | **38,925,400.00** | **3,022,200.00** | 92.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,540,600.00 | 26,471,800.00 | 2,068,800.00 | 92.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,382,200.00 | 3,114,600.00 | 267,600.00 | 92.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,691,000.00 | 1,557,700.00 | 133,300.00 | 92.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,569,300.00 | 1,557,700.00 | 11,600.00 | 99.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,764,500.00 | 6,223,600.00 | 540,900.00 | 92.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,571,370.00** | **47,559,833.69** | **2,011,536.31** | 95.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,000,000.00 | 4,088,494.56 | 1,911,505.44 | 68.14 |
| 210302 | Түлш, халаалт | 43,471,370.00 | 43,471,339.13 | 30.87 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | | 100,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **33,597,300.00** | **26,504,590.00** | **7,092,710.00** | 78.89 |
| 210502 | Хоол, хүнс | 33,597,300.00 | 26,504,590.00 | 7,092,710.00 | 78.89 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,000,000.00** | **3,117,350.00** | **882,650.00** | 77.93 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 3,117,350.00 | 882,650.00 | 77.93 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,669,100.00** | **610,000.00** | **1,059,100.00** | 36.55 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,669,100.00 | 610,000.00 | 1,059,100.00 | 36.55 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,488,700.00** | **13,278,662.00** | **3,210,038.00** | 80.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,632,800.00 | 11,008,342.00 | 2,624,458.00 | 80.75 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,855,900.00 | 2,270,320.00 | 585,580.00 | 79.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **5,868,816.31** | (5,868,816.31) | |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | | 2,974,600.00 | (2,974,600.00) | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 2,974,600.00 | (2,974,600.00) | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **2,894,216.31** | (2,894,216.31) | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,894,216.31 | (2,894,216.31) | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **940,000.00** | (940,000.00) | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | 940,000.00 | (940,000.00) | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 940,000.00 | (940,000.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **488,592,200.00** | **462,375,938.30** | **26,516,261.70** | **95.24** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **435,020,800.00** | **411,388,754.61** | **23,632,045.39** | **95.25** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 435,020,800.00 | 411,388,754.61 | 23,632,045.39 | 95.25 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **53,571,400.00** | **50,677,183.69** | **2,894,216.31** | **94.62** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 53,571,400.00 | 50,677,183.69 | 2,894,216.31 | 94.62 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **83,734,042.01** | **83,734,042.01** | - | 100.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **39,140,703.71** | **39,140,703.71** | - | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **11** | **11** | - | 100.00 |

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана" гэж заасны дагуу Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК"-ийн аудитын баг С.Дарьсүрэн, Б.Хоролбат нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт зардалыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлаас 384,870.2 мянган төгрөгийн 1.5 хувь 5,773.05 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 4,329.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл"-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно. Тус байгууллага нь орон нутгийн санхүүжилтээс 1,059.5 мянган төгрөгийг хэмнэн буцаан төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймгийн Орхон сумын Хүүхдийн цэцэрлэг  нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 169 мэдээллийг бүрэн оруулж, 1 мэдээлэл хугацаа хоцроон, 2 мэдээлэл орхигдуулан мэдээлсэн байна.

*Илрүүлэлт:* Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 169 мэдээллийг бүрэн оруулж, 1 мэдээлэл хугацаа хоцроон, 2 мэдээлэл орхигдуулан мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч", Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч" 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

**Албан шаардлага**

*Илрүүлэлт:*

Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт

өртгийн дээд хязгаар, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Албан шаардлага/

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***:

Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөн баталж, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх.

---

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт, худалдан авах ажиллагааны гэрээ, тендэр шалгаруулалт зэргийг анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 12.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 12.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн асуудлаас 12.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул **“Өөрчлөлтгүй дүгнэлт”** өглөө.

### 5.1 Албан шаардлага

**5.1.1** *Илрүүлэлт:* Жилийн эцсийн тооллогыг хийхдээ тооцоо бодсон акт байхгүй, бүртгэлийг 12,500.0 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь тооллогын чанартай үнэн зөв хийгээгүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Алдаа зөрчилийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага

### 5.2 Зөвлөмж

5.2.1 *Илрүүлэлт:* Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглаагүй, бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулж, анхан шатны баримтыг ихэнхийг гараар хөтөлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т 'тасралтгүй байх' гэсэн зарчим, 13.1' Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно' гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Цаг тухай бүрд нь орлого, зарлагын гүйлгээг программд оруулан  шивж байх, санхүүгийн программыг бүрэн эзэмшиж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж өгөх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн прогроммыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа бараа материалыг сараар түүвэрлэн сарын сүүлчийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Жилийн эцсийн тооллогыг хийхдээ тооцоо бодсон акт байхгүй, бүртгэлийг 12,500.0 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь тооллогын чанартай үнэн зөв хийгээгүй | 1 | 12.5 | | | 1 | 12.5 | | | | | | |
| **Дүн** | **2** | **12.5** | **-** | **-** | **1** | **12.5** | **1** | **0** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 104 мэдээллийг бүрэн оруулж, 3 мэдээлэл хоцорч мэдээлсэн 64 огт мэдээлээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Нийт дүн | 2 | 0 | | | 1 | 0 | 1 | 0 |